

**“Зоонозын халдварын тулгамдсан асуудал” олон улсын эрдэм шинжилгээний
хуралд хэлэлцүүлэх материалд тавигдах шаардлага**

Зоонозын гаралтай шинээр болон сэргэн тархаж буй халдварт өвчин, анзаарагддаггүй өвчин зэрэг сэдвийн хүрээнд гүйцэтгэсэн судалгааны ажлын үр дүнгээ дотоодын болон олон улсын судлаачдад түгээх, туршлага, мэдлэгээ харилцан солилцох зорилгоор эрдэмтэн, судлаач та бүхэн өөрийн илтгэлийн хураангуйг дараах шаардлагын дагуу бичиж ирүүлнэ үү.

Илтгэлийн хураангуйд тавигдах шаардлага:

1. Хурлын илтгэлийг зөвхөн хураангуй (abstract) хэлбэрээр Монгол, Англи хэлээр товч тодорхой бичнэ.
2. Хураангуйн эхэнд бүтээлийн нэр, зохиогчийн нэр, зохиогчийн харъяалагдах байгууллагын нэр, гол судлаачийн и-мэйл хаягийг бичнэ. Жишээ нь:

Болд Г.¹, Бат Ц.²

¹Шинжлэх ухааны академи

²Зоонозын өвчин судлалын үндэсний төв

И-мэйл: bat@nczd.gov.mn

3. Үсгийн фонт: Arial, үсгийн хэмжээ 12, мөр хоорондын зай 1 (Single)
4. Илтгэлийн хураангуйг удиртгал, материал, арга зүй, үр дүн, хэлцэмж, дүгнэлт гэсэн бүрэлдэхүүн хэсгүүдийг баримтлан боловсруулсан байх ба ном зүйн жагсаалтыг оруулах шаардлагагүй.
5. Монгол, Англи хураангуй нь ижил агуулгатай байх бөгөөд тус бүр 500 хүртэлх үгэнд багтаан бичсэн байна. Түлхүүр үгийг Монгол, Англи хувилбарт адилхан оруулна.
6. Илтгэлийн хураангуйг altantogtokh@nczd.gov.mn, tserennorov@nczd.gov.mn nczd@nczd.gov.mn цахим хаягаар **2025 оны 06 дугаар сарын 20**-ийг хүртэл хүлээн авна.
7. Хурлын Редакцийн зөвлөл илтгэлийн хураангуйг хянан тохиолдуулж сонгон шалгаруулсны дараа илтгэх цагийг баталгаажуулсан хөтөлбөрийг танд илгээх болно.
8. Тус олон улсын хуралд ирүүлсэн материалуудыг хурлын эмхэтгэлд нийтэлж, олон нийтэд түгээх болно.

Холбоо барих: Зоонозын өвчин судлалын үндэсний төв

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, 18131, Сонгинохайрхан дүүрэг 20 дугаар хороо

Утас: +976 70282853, +976 99040664, www.nczd.gov.mn.